

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ХЭНТИЙ АЙМГИЙН ХУДАЛДАА, БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



ХЭНТИЙ АЙМАГ  
2014 ОН

## **АГУУЛГА**

**Нэг. Судалгааны зорилго**

**Хоёр. Салбаруудын үүсэл хөгжил**

- Худалдааны салбарын үүсэл хөгжил
- Барилгын салбарын үүсэл хөгжил

**Гурав. Аймгийн нутаг дэвсгэрт худалдааны үйл ажиллагаа явуулах бизнесийн орчин**

**Дөрөв. Аймгийн худалдаа үйлчилгээний салбарын өнөөгийн байдал**

- Худалдааны салбарын нийт борлуулалт, нэмэгдэл өртгийн хэмжээ, аймгийн ДНБ-нд нэмэгдэл өртгийн эзлэх хувь
- Худалдааны салбарын ажилчдын тоо
- Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо
- Судалгааны хэсэг

**Тав. Барилгын салбарын нийт үйлдвэрлэл, өнөөгийн байдал**

**Зургаа. Дүгнэлт**

## **1. Судалгааны зорилго**

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтээр нэгдсэн танилцуулга бэлтгэн, эдгээр үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлон, орон нутгийн удирдлага болон бодлого хариуцсан ажилтнуудыг мэдээллээр хангахад чиглэнэ.

## **2. Салбаруудын үүсэл хөгжил**

### *Худалдааны салбар*

Монгол улсын худалдааны салбарын үүсэл хөгжил 90 гаруй жилийн түүхтэй бөгөөд хүнсний болон өргөн хэрэглээний барааны эн тэргүүний хэрэглээг хангах зорилгоор эд хэрэглэгчдийн анхны хоршоо байгуулагдсанаар өнөөгийн худалдааны салбарын хөгжлийн эх үүсвэр тавигдсан. Худалдааны салбарын хөгжлийн явцад гадаад худалдаа, худалдаа бэлтгэл, эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг дэвшилттэй шийдлүүд гарч ирсэн.

2014 онд улсын хэмжээнд бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 15.6 их наяд төгрөг болж, өмнөх оныхоос 1159.7 тэрбум.төгрөг буюу 8.0 хувиар, зочид буудлын салбарын нийт үйлдвэрлэлт урьдчилсан гүйцэтгэлээр 174.7 тэрбум.төгрөг болж, өмнөх оныхоос 17.0 тэрбум.төгрөг буюу 10.7 хувиар өсч, нийтийн хоолны салбарын нийт үйлдвэрлэл 326.1 тэрбум.төгрөг болж, өмнөх оныхоос 8.0 тэрбум.төгрөг буюу 2.4 хувиар буурсан байна.

Зах зээлийн нийгэмд шилжиж худалдааны салбарын нэгжүүд хувьд шилжиж худалдаа бэлтгэл, нийтийн хоолны үйлчилгээн дэх чанарын хяналт алдагдаж, ард иргэдийг экспортын болон үндэсний экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах асуудал тавигдаж байгаа

билээ. Юуны өмнө алслагдсан аймаг орон нутгийн хэрэглэгчдэд бараа худалдаалах, тэдгээрээс мал аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдан авах бөөний худалдааны сүлжээ бүрдүүлэх төдийгүй интернэтэд суурилсан эргэх буцах мэдээллийн урсгалыг багтаасан зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлага тавигдаж байгаа юм. Иймд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг байнга судлан түүнд бараа үйлчилгээг нийцүүлэх, зах зээлийн мэдрэмжийг олж харах талаар шинийг эрэлхийлэн ажиллах хэрэгтэй байна.

Худалдааны салбарт худалдаа нийтийн хоол зочид буудлын салбарын эдийн засгийн үзүүлэлтэд ажиллагсадын тоо, бараа бүтээгдэхүүний борлуулалт, зардал үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүд ордог.

### *Барилгын салбарын үүсэл хөгжил*

Барилгын үүсэл хөгжлийг үечлэн авч үзвэл эхний шат буюу 1926 -1930 он барилгын байгууллага цогцоороо үүсэн бий болсон жилүүд байлаа.1931-1945 онд барилга улс ардын аж ахуйн салбар болж хөгжив.1946-1965 он барилгын салбарын хувьд их бүтээн байгуулалтын үе байв.1965-1989 он барилгын материал техникийн бааз суурь бэхжсэн,улс ардын аж ахуйн тэргүүлэх салбар боллоо.

1980-1990 оны үе нь Монголын барилгын байгууллагуудын хөгжлийн оргил үе байсан бөгөөд жилдээ 5000 м квадрат хүртэл талбайтай орчин үеийн тохилог орон сууц, олон үйлдвэр, барилгуудыг ашиглалтад өгсөн байна. Харин 1991-1995 он барилгын салбарын үйл ажиллагаа үндсэндээ зогсолтод орсон үе байв. 1996 оноос барилгын үйлдвэрлэл сэргэх хандлагатай болж хувийн хөрөнгө оруулалттай контор,үйлчилгээний зориулалттай жижиг барилгуудыг барих болсон юм. Шилжилтийн эдийн засгийн үед зогсонги байдалд ороод байсан Монголын барилгын салбар 2001 оноос эхлэн сэргэж,

өнөөг хүртэл эрчимтэй хөгжиж ирлээ. Үүнд Монгол Улсын гадаад худалдааны таатай орчин, банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, хүн амын орлогын өсөлт зэрэг нь эерэгээр нөлөөлсөн.

2015 онд манай аймгийн барилгын салбарын түүхт 55 жилийн ой тохиож байгаа, аймгийн хэмжээнд нийт барилгын салбарт 59 аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс 40 –өөд аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Жил ирэх тусам барилга угсралтын ажлын хэмжээ, цар хүрээ нэмэгдэж шинэ материал техник технологийг өргөн нэвтрүүлж байгаа нь барилгын компаниудын ажил үйлчилгээний чанар сайжирч, санхүүгийн чадавх дээшлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.


### **3. Аймгийн нутаг дэвсгэрт худалдааны үйл ажиллагаа явуулах бизнесийн орчин**

Аймгийн хэмжээнд 2014 оны жилийн эцсийн байдлаар 71065 хүн ам, 22634 өрх бүртгэгдсэн. Мөн Хэнтий аймагт регистрийн санд бүртгэлтэй 1256 аж ахуйн нэгж байгууллагабайгаагаас одоо үйл ажиллагаа явуулж байгаа 948 аж ахуйн нэгж байгууллага байна. БНХАУ-ын Манжуур, Хөлөнбуйр, Алтан-Эмээл, Амгаланбаатар хотуудтай, ОХУ-ын Чита, Агийн буриад, Турк, Кувейт улстай найрамдал хамтын ажиллагаатай ажилладаг, монголыг арилжааны банкны Хаан, Хас, Капитал,Төрийн банкны салбартай, худалдааны 400 гаран цэг үйл ажиллагаа эрхэлдэг.

#### **4. Аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбарын өнөөгийн байдал**

Аймгийн хэмжээнд өнөөгийн байдлаар 400 орчим худалдаа үйлчилгээний ААН үйл ажиллагаа явуулдаг үүнээснь хүнсний худалдаа эрхэлдэг 237, шатахуун түгээх үйл ажиллагаа эрхэлдэг 41, эмийн худалдаа эрхэлдэг 24, өргөн хэрэглээний барааны худалдаа эрхэлдэг 79 ААН байна.

**Нийт дүнд салбаруудын эзлэх хувийн жин**



Аймгийн худалдааны салбар 2014 онд 13077.9 сая төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх оныхоос 3796.7 сая төгрөгөөр буюу 29 %-иар өссөн борлуулалттай байна.

2014 онд 1000 хүнд ноогдох борлуулалтын хэмжээ 184.0 сая.төг байгаа нь өмнөх 2013 оноос 49.9 сая.төг-өөр өссөн үзүүлэлт гарлаа.

## Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар

2014 оны өргөн хэрэглээ бараа үйлчилгээний үнийн өсөлт 2014оныхтой харьцуулахад их байсны улмаас нийт гаргалт өссөн байдалтай харагдаж байна.

### Нэг хүнд ногдох худалдааны цэг

Аймаг	2011	2012	2013	2014
Дорнод	55	48	51	56
Сүхбаатар	63	91	89	94
Хэнтий	59	39	53	50
Зүүн бүс дүн	59	50	59	60

### Худалдааны салбарын нийт гаргалт нэмэгдэл өртөг завсрын хэрэглээ

*/Хүснэгт-1/*

№	Он	Нийт үйлдвэрлэлт	Нэмэгдэл өртөг	Завсрын хэрэглээ
1	2007	3991.3	505.8	3485.5
2	2008	4691	489.6	4201.4
3	2009	4498.4	710.7	3787.7
4	2010	6442.1	776.2	5665.9
5	2011	7360.8	675.6	6685.2
6	2012	8996.6	941.0	8055.6
7	2013	9281.1	1118.4	8162.7
8	2014	13077.9	1299.5	11778.4

## Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар

Үзүүлэлт	Дүн /сая.төгрөг/		Аймгийн НБ-нд эзлэх хувь	
	2013	2014	2013	2014
Нэммэгдэл өртөг	1118.4	1299.5	0.3	0.4

Аймгийн нэмэгдэл өртгийн 0.4 хувийг худалдааны салбарт бий болж, энэ нь өмнөх оноос 0.1 пунктээр өссөн байна.

### 1. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

#### Б. Спирмений корреляцийн хамаарал

*/Хүснэгт-2/*

№	Он	Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ /сая.төг/	ДНБ	Nx	Ny	Nx-Ny	d <sup>2</sup>
		X	Y				
1	2009	710.7	54678.7	2	1	1	1
2	2010	776.2	86770.2	3	2	1	1
3	2011	675.6	157992.2	1	3	-2	4
4	2012	941.0	206483.3	4	4	0	0
5	2013	1118.4	283208.1	5	5	0	0
6	2014	1299.5	347294.3	6	6	0	0
Дүн							6

Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ үр ДНБ-нд хэрхэн нөлөөлж байгааг хамаарлын хүчийг хэмжих энгийн арга болох Спирмений корреляцийн аргаар тооцлоо.

**Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар**


Ингэхэд: 
$$\rho = 1 - \frac{6 \sum d^2}{n(n^2 - 1)} = 1 - \frac{6 * 6}{6(36 - 1)} = 0.8$$

Коэффициентийн утга / 0.8/ буюу хүчин зүйлийн үзүүлэлт үр дүнгийн үзүүлтэнд шууд хамааралтай байна

**Б.Динамик эгнээний шинжилгээ.**

*/Хүснэгт-3/*

Он	Худалдааны салбарын нийт гаргалт, /сая.т	3 үеийн голчилсон хөвөгч дундаж	Хөвөгч дундаж ба бодит тооны харьцаа
2006	2488.3	2315.5	107.4
2007	3991.3	3723.5	107.1
2008	4691.0	4393.5	106.7
2009	4498.4	5210.5	86.3
2010	6442.1	6100.4	105.6
2011	7360.8	7599.8	96.9
2012	8996.6	8546.2	105.2
2013	9281.1	10451.8	88.8
2014	13077.9	-	-



## Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар

3 үеийн хөвөгч дундажыг тооцсон нь харьцангуй жигд өсөлттэй гарлаа. 2014 оны хөвөгч дундаж ба бодит тооны харьцаа өндөр байгаа нь 2014 оны нийт гаргалтын хэмжээ өссөнтэй холбоотой харагдаж байна.

*В.Динамик эгнээний хандлагын шинжилгээ/Хүснэгт-4 /*

Он	Худалдааны салбарын нийт гаргалт, /сая.төг/	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд (%)	Хэлхээ цэвэр өсөлт, бууралтын хурд (%)	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
2005	2488.3	0	0	0	0.4
2006	3991.3	1503.0	160.4	60.4	24.8
2007	4691.0	699.7	117.5	17.5	39.9
2008	4498.4	-192.6	95.8	-4.2	46.9
2009	6442.1	1943.7	143.2	43.2	44.9
2010	7360.8	918.7	114.2	14.2	64.4
2011	8996.6	1635.8	122.2	22.2	73.6
2012	9281.1	284.5	103.2	3.2	88.9
2013	13077.9	3796.8	140.9	40.9	92.8

2006-2014 оны худалдааны салбарын нийт гаргалт дээр динамик хандлагын шинжилгээ хийж үзэхэд 2009 онд өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлт бага байсан тул өсөлтийн хурд харьцангуй багассан нь харагдаж байна.

Энэ нь өргөн хэрэглээний барааны үнэ нийт гаргалтанд шууд нөлөөтэйг баталж байна. 2010 онд 2009 оныхоос 43,2хувиар өссөн, 2011 онд 2010 оныхоос 14.2 хувиар өссөн, 2012 онд 2011 оноос 22.2 хувиар өссөн, 2014 онд 40.9 хувиар өссөн байна.

Тав. Барилгын салбарын нийт үйлдвэрлэл, өнөөгийн байдал

**БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ**

*Total amount of construction*

/өссөн дүнгээр, мянган төгрөгөөр/

	Объектын нэр	Гүйцэтгэл
1	Хан Хэнтий язгууртан хороолол	1540000
2	Хэрлэн хороололд 50 айлын орон сууц	1960000
3	Хэрлэн хороололд 54 айлын орон сууц	3000000
4	Хэрлэн хороололд 54 айлын орон сууц	3000000
5	4-р багт амины орон сууц	295000
6	Татварын хэлтсийн хойд талд 5 давхар орон сууц	330000
7	Тариаланчид гудамж Ц-03 48 айлын орон сууц	286608
8	4-р багт амины орон сууц	145600
9	Хэрлэн хороололд 42 айлын орон сууц	1265000
10	Хэрлэн хороололд 42 айлын орон сууц	800000
11	4-р багт 30 айлын орон сууц	600000
12	Батноров сумын ЕБС-н дотуур байрын б/угсралт	295000
13	Норовлин сумын ЕБС-н дотуур байрын б/угсралт	1500000
14	Хан Хэнтий цогцолбор сургуулийн өргөтгөлийн барилга угсралт	400000
15	Хэрлэн сум ЕБС-н барилга угсралт	3000000
16	Мөрөн сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга	198000
17	Олимп цогцолбор	799240.8
18	Жаргалтхаан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралт	94023.3
19	Баян-овоо сум ХААН банкны барилга	107000
20	Баян-овоо сум ЭМТ-н барилгын засвар	55426.9
21	Хэрлэн сум Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга	1989000
22	Баянмөнх сум ЕБС-н дотуур байрын б/угсралт	202000
23	Галшар сумын соёлын төвийн барилгын их засвар	39337
24	Аймгийн номын сангийн барилгын засвар	39225.2

**Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар**


25	Галшар сумын ёслол хүндэтгэлийн өргөөний их засвар	35000
26	Хэрлэн сумын ЗДТГ-н засвар	28000
27	Өмнөдэлгэр сумын цэцэрлэгийн засвар	38000
28	Өмнөдэлгэр сумын 3-р багийн соёлын төвийн барилга	45000
29	Батноров сумын ЕБС-н дээврийн засвар	68000
30	Хэрлэн сум 1-р баг Худалдаа үйлчилгээний төв	220000
31	БСГазрын засвар	63624.9
32	Норовлин сум цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа	19086.5
33	Хурх тосгон цэцэрлэгийн барилгын засвар	38000
34	Хэрлэн сум усан бассейны засвар	119500
35	Хэрлэн сум бетон зуурмагийн үйлдвэр	630000
36	Дархан сум цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	18100
37	Хэрлэн сум өвгөн ноёны гэр музейн барилга	68900
38	Баян-овоо сум Наран баг хөгжлийн төвийн барилга	68900
39	Бэрх тосгоны соёлын ордоны засвар	94000
40	Хэрлэн сум 3-р багийн төв	193000
41	Хэрлэн сум БГХӨСТөвийн барилга	120000
42	Хэрлэн сум хүнсний ногооны агуулах	84500
43	Бэрх тосгоны бага сургуулийн барилга угсралт	762228.1
44	Бор-Өндөр сумын ЕБС-н сантехникийн засвар	158275.5
45	Баянхутаг сум Ахмадын сувилалын барилга	37889.4
46	Баянхутаг сум Халуун усны барилга	64268.6
47	Биндэр сум хэсгийн төлөөлөгчийн кабон	75517.1
48	Баянхутаг сум Ахмадын төвийн барилга	46395
49	Баянхутаг сумын ЭМТ-н сантехникийн засвар	15000
50	Галшар сум ЭМТ-н барилгын засвар	97500
51	Баянмөнх сум ЭМТ-н барилгын засвар	96200
52	Бор-Өндөр сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралт	250000
53	Хэрлэн сум соёлын төвийн засвар	15000

54	Авто граж	95500
----	-----------	-------


### Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар

55	Амины орон сууцны инженерийн шугам сүлжээ	332224
56	Хэрлэн сум 8-р багт гүний худаг	14500
57	Хэрлэн сум 8-р багт гүний худгийн засвар	17000
58	Хэрлэн сум 7-р багт гүний худгийн засвар	24000
59	Хэрлэн сум 2-р багт гүний худаг	6500
60	Батноров сум 2-р багт гүний худаг	15000
61	Галшар сум 3-р багт гүний худаг-5	79000
62	Өмнөдэлгэр сум худгийн засвар	20000
63	Хэрлэн голын төмөр бетон гүүр	1425000
64	Хэрлэн сум явган хүний замын ажил	144167.9
65	Өндөрхаан-Мөнххаан -Баруун-Уртын чиглэлийн 45.3 км хатуу хучилттай авто зам	11055157.1
66	Нисэх буудлын хөөрч буух шороон зурвасны засвар	50400
67	Чингис-Норовлин-Баянуул чиглэлийн хайрган хучилттай авто зам	119000
68	Чингис хотын төвд асфальтбетон хучилттай авто зам	962000
69	Чингис хотын доторх сайжруулсан шороон замын засвар	8748.6
70	Чингис-Дадал чиглэлийн хайрган замын засвар	84522.9
71	Чингис-Чойбалсан чиглэлийн хайрган хучилттай авто замын засвар	31000
72	Хэрлэн сум хайрган хучилттай авто замын засвар	20000
73	Чингис- Улаанбаатар чиглэлийн хатуу хучилттай авто замын засвар	775100
74	Чингис-Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай авто замын засвар	164000
75	Норовлин сумын төвд зам хусч тэгшлэх засвар	20000
<b>Бүгд</b>		<b>40973166.8</b>

**Барилга угсралт их засварын ажлын динамик /сая.төг/**



**Барилга угсралт их засвар /салбараар, сая.төг/**



**Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар**

**Барилга угсралт, их засварын ажил  
/сая,төг/**



<b>Барилга угсралт их засварын ажил -2014</b>	<b>Гүйцэтгэл</b>
Орон сууцны барилга	13217.9
Орон сууцны барилга, гарааштай	100.0
Үйлдвэрийн	630.0
Худалдаа, үйлчилгээний	284.3
Эмнэлэг	2004.0
Цэцэрлэг	542.0
Сургууль	5833.2
Соёлын	556.9
Спорт, биеийн тамир	799.2
Конторын	144.4
Орон сууцны бус бусад барилга	491.3
Хатуу хучилттай авто зам	12055.2
Сайжруулсан хөрсөн зам	8.7
Төмөр бетон гүүр, гүүрэн гарц	1425.0
Далан, суваг, шугам	332.2
Бусад (бусад зам, талбайн ажил)	307.3
Орон сууцны бус барилгын их засвар	1030.1

Инжежерийн барилга байгууламжийн их засвар	1211.4
<b>Дүн</b>	<b>40973.2</b>

---

## **Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар**

---

### **Дүгнэлт**

Аймгийн худалдааны салбар 2014 онд 13077.9 сая төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх оныхоос 3796.7 сая төгрөгөөр буюу 29 %-иар өссөн борлуулалттай байна.

2014 онд 1000 хүнд ноогдох борлуулалтын хэмжээ 184.0 сая.төг байгаа нь өмнөх 2013 оноос 49.9 сая.төг-өөр өссөн үзүүлэлт гарлаа.

2014 оны өргөн хэрэглээ бараа үйлчилгээний үнийн өсөлт 2013 оныхтой харьцуулахад харьцангуй их байсны улмаас нийт гаргалт өссөн байдалтай харагдаж байна.

3 үеийн хөвөгч дундажыг тооцсон ч харьцангуй жигд өсөлттэй гарлаа. 2013оны хөвөгч дундаж ба бодит тооны харьцаа өндөр байгаа нь 2014 оны нийт гаргалтын хэмжээ өссөнтэй холбоотой харагдаж байна.

2006-2014 оны худалдааны салбарын нийт гаргалт дээр динамик хандлагын шинжилгээ хийж үзэхэд 2009 онд өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлт бага байсан тул өсөлтийн хурд харьцангуй багассан нь харагдаж байна.

Энэ нь өргөн хэрэглээний барааны үнэ нийт гаргалтанд шууд нөлөөтэйг баталж байна. 2005 оны худалдааны салбарын нийт гаргалт нь 2004 онтой харьцуулахад өсөлтгүй, 2006 оны үзүүлэлт 2005 оныхоос 432,7%, 2007 онд 2008 оныхоос 60.4 хувиар өссөн, 2008 онд 2007 оныхоос 17.5 хувиар өссөн, 2009 онд 2008 оныхоос 4.2 хувиар буурсан, 2010 онд 2009 оныхоос 43.2хувиар өссөн,2011 онд 2010 оныхоос 14.2 хувиарөссөн, 2012 онд 2011 оноос 22.2 хувиар, 2014онд 2013 оноос 40.9 хувиар тус тус өссөн байна.

## **Хэнтий аймгийн худалдаа үйлчилгээ, барилгын салбар**

---

Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ ДНБ-нд хэрхэн нөлөөлж байгааг хамаарлын хүчийг хэмжих Спирмений корреляцийн аргаар тооцоход коффецентийн утга 0.8 буюу хүчин зүйлийн үзүүлэлт үр дүнгийн үзүүлтэнд урвуу хамааралтай байна.

Аймгийн барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 20 гаруй аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээ, мэдээлэл авч танилцуулгандаа орууллаа.

Эдгээр аж ахуй нэгж, байгууллага нь 70 гаруй объектод нийт 40973,2 саятөгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 23.0хувь буюу 9413,6 сая төгрөгөөр өссөн байна.

2014 онд барилга угсралтын ажилд 38731.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс авто зам, гүүрийнажилд13488.9 сая, соёл спортын салбарт 1356.1 сая, эрүүл мэндийн салбарт 2004.0 сая, боловсролын салбарт 6375.2 сая, орон сууцны барилгад13317.9 сая төгрөг, бусад барилга байгууламжид 2189,6 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт гүйцэтгэлийн 95.0 хувийгбарилга угсралт, 5.0 хувийг их засварын ажил эзэлж байна.

Жил ирэх тусам барилга угсралтын ажлын хэмжээ, цар хүрээ нэмэгдэж шинэ материал техник технологийг өргөн нэвтрүүлж байгаа нь барилгын компаниудын ажил үйлчилгээний чанар сайжирч, санхүүгийн чадавх дээшлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Гүйцэтгэсэн

Г.Сэдэлмаа